



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/454

Булган сум

Агентлаг, байгууллагын дарга нарын 2025 оны
гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэх тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, 52.2, 52.3, Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Журам батлах тухай”, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.9, 4.10 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийн үнэлгээг хавсралтаар баталсугай.

2. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээг үндэслэн холбогдох журмын дагуу урамшуулал олгохыг тухайн байгууллагын төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010625

Аймгийн Засаг даргын 2025 оны
06 сарын 27-ны өдрийн 1/457 тоот
захирамжийн хавсралт

Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг,
байгууллагуудын 2025 оны гүйцэтгэлийн
төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтийн үнэлгээ

Д/д	Агентлаг, байгууллагуудын нэр	Үнэлгээ хувиар	Хугацаа	Урамшууллын хувь/ Үндсэн цалингийн
1	Аймгийн Засаг даргын тамгын газар	85.6	I, II улирал	100 хувь
2	Онцгой байдлын газар	96.2		100 хувь
3	Цагдаагийн газар ✓	85.2		100 хувь
4	Шүүх шинжилгээний хэлтэс ✓	92.06		100 хувь
5	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	90.8		100 хувь
6	Улсын бүртгэлийн хэлтэс ✓	92.7		100 хувь
7	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар ✓	96.7		100 хувь
8	Татварын газар ✓	99.2		100 хувь
9	Орон нутгийн өмчийн газар ✓	88.0		100 хувь
10	Худалдан авах ажиллагааны газар	95.3		100 хувь
11	Боловсролын газар ✓	69.0		60 хувь
12	Эрүүл мэндийн газар ✓	83.0		80 хувь
13	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар ✓	84.0		80 хувь
14	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар ✓	90.6		100 хувь
15	Нийгмийн даатгалын газар ✓	100		100 хувь
16	Биеийн тамир, спортын газар ✓	95.0		100 хувь
17	Хүнс хөдөө аж ахуйн газар ✓	85.0		100 хувь
18	Байгаль орчны газар ✓	86.0		100 хувь
19	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар ✓	91.0		100 хувь
20	Мал эмнэлгийн газар ✓	87.0		100 хувь
21	Статистикийн хэлтэс ✓	93.01		100 хувь
22	Стандарт, хэмжил зүйн хэлтэс ✓	92.7		100 хувь
23	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв ✓	90.0		100 хувь
23	Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар ✓	84.4		80 хувь
24	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс	86.5		100 хувь
25	Музей ✓	93.0		100 хувь
26	Хөгжимт жүжгийн театр ✓	85.0		100 хувь
27	Аймгийн Төв номын сан ✓	92.8	100 хувь	